**Монгол Улс**
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт**
**2017 оны 8-р сарын 31**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мейл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 31-нд 15 дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

| **Ангилал** | **Оролцогчдын санал** |
|---|---|

| | |
|---|---|
| **Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)** | **<u>Сорилтууд</u>**<br><br>**Засаглал:**<br><br>• Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу<br>• Төрийн бодлогын хэрэгжилт тогтвортой биш, урт хугацааны бодлогын хэрэгжилт сул бөгөөд хэрэгжилтийг дэмжих хууль эрх зүйн хүрээ байхгүй<br>• Бодлогын хэрэгжилтийг дэмжих хяналт, шалгалтын хүрээ үр дүнгүй бөгөөд сул<br>• Засгийн газарт авлигал газар авсан<br>• Төр засаг хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хэтэрхий их оролцдог<br><br>**Дэд бүтэц, макроэдийн засгийн нөхцөл байдал:**<br><br>• Төмөр зам, зам тээвэр, логистикийн төв зэрэг хувийн хэвшлийг дэмжих дэд бүтэц сул. Дэд бүтцийг хөгжүүлэхийн тулд төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хэрэгтэй.<br>• Эдийн засгийн төрөлжилт сул, уул уурхайн салбараас маш их хамааралтай<br>• Том хэмжээний стратегийн төслүүдийг хэрэгжүүлж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг байдаггүй<br><br>**Санхүүгийн хүртээмж, хүний нөөц:**<br><br>• Урт хугацааны санхүүжилт болон хөрөнгө оруулалт дутмаг. Санхүүжилт өндөр өртөгтэй.<br>• ЖДҮ-үүд өөрсдийн үйл ажиллагааг тэлэх чадавх, чадвар дутмаг байдаг<br><br>**Боломж болон хамтын ажиллагааны чиглэлүүд:**<br><br>• Засгийн газарт ажиллаж байгаа холбогдох мэргэжилтнүүдийн ур чадвар, чадавхийг сайжруулах<br>• Төрийн болон хувийн байгууллагуудын засаглал, хариуцлагын тогтолцоог сайжруулах<br>• Урт хугацааны санхүүжилтийн олдоцыг нэмэгдүүлж, нөхцөлийг нь илүү уян хатан болгох шаардлагатай<br>• Хөрөнгийн зах зээл гэх мэт санхүүжилт, хөрөнгө оруулалтын өөр эх үүсвэрүүдийг хөгжүүлэх<br>• Зарим чухал төслүүдийг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээг хийх дээр хувийн хэвшилтэй хамтран ажиллах<br>• Эрүүл мэнд нь ядууралтай холбоотой гол хүчин зүйлсийн нэг тул улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцооны үйл ажиллагаа, менежментийг сайжруулах<br>• Ижил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн байгууллагуудын шилдэг туршлагуудыг бусадтайгаа хуваалцах, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих хэрэгтэй. |

| | |
|---|---|
| | • Засгийн газрын бодлогын хэрэгжилтийн хяналт шалгалтын хүрээг сайжруулах.<br>• Санхүүгийн технологийг ашиглах ядуу болон нэн ядуу иргэдэд хүрэх шинэлэг үйлчилгээнүүдийг бий болгох, судлах.<br>• Татварын хувь хэмжээг нэмэхээс илүүтэйгээр татварын суурь баазыг нэмэхийг судлах.<br>• ДБГ-ын шилдэг туршлага, төслөөс суралцах боломжийг судлах<br>• Боловсролын чанарыг сайжруулахад анхаарах, тэр дундаа бага сургууль болон их дээд сургуулиудын чанар. Багш нарын чадавх, ур чадвар, амьдрах нөхцлийг сайжруулах.<br>• Байгалийн баялгийн менежментийг илүү үр ашигтай болгох.<br>• Хамгийн ач холбогдолтой гол салбаруудад өсөлтийг дэмжихийн тулд шаардлагатай дэд бүтэц, логистикийн төвүүдийг байгуулах.<br>• Уул уурхайн салбар бусад салбарт эрэлт үүсгэж, ажлын байрыг шууд бусаар нэмэгдүүлдэг.<br>• “Органик сүү, сүүн бүтээгдэхүүн” гэсэн Монгол брэндийг хөгжүүлэхэд анхаарах. |

| | |
|---|---|
| **ДБГ-ын дэмжлэг, оролцооны тал дээр ирүүлсэн санал** | **Арга зам болон хэрэгжилт:**<br><br>• Өмнөх туршлага дээрээ үндэслэн төрийн байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжилтэн, албан хаагчдын чадавх, ур чадварыг дэмжих илүү үр ашигтай арга замыг эрэлхийлж бий болгох.<br>• Хувийн хэвшлийн байгууллагуудтай холбогдолтой гол төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхдээ хувийн хэвшилтэй уялдаа холбоотой ажиллах, тэдэнтэй зөвлөлдөх.<br>• Боловсрол, эрүүл мэндний салбарын төсвийн нийт төсөвт эзлэх хувийг нэмэгдүүлэх тал дээр Засгийн газарт ДБГ-с зөвлөмж өгөх.<br>• Мэдлэг, сайн туршлага хуваалцаж, Засгийн газар, хувийн хэвшил болон олон улсын түншүүдийг нэг дор цуглуулж, хамтран ажиллахад түлхэц болдог ДБГ-ын давуу талыг ашиглах. |

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

| | |
|---|---|
| – Төрийн удирдлага/шинэтгэл | 72.73% 8 |
| – Эрүүл мэнд | 72.73% 8 |
| – Боловсрол | 72.73% 8 |
| – Хувийн хэвшлийг хөгжүүлэх | 27.27% 3 |
| – Байгалийн нөөцийн удирдлага | 27.27% 3 |
| – Гадаадын хөрөнгө оруулалт | 27.27% 3 |
| – Санхүүгийн зах зээл | 27.27% 3 |
| – Ус, ариун цэврийн байгууламж | 18.18% 2 |
| – Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт | 18.18% 2 |
| – Авлигатай тэмцэх | 18.18% 2 |
| – Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан | 18.18% 2 |

| | |
|---|---|
| – Худалдаа, экспорт | 18.18% 2 |
| – Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах | 18.18% 2 |
| – Хүнсний аюулгүй байдал | 9.09% 1 |
| – Эдийн засгийн өсөлт | 9.09% 1 |
| – Зам, тээвэр | 9.09% 1 |
| – Хөдөөгийн хөгжил | 9.09% 1 |
| – Хотын хөгжил | 9.09% 1 |
| – Эрчим хүч | 9.09% 1 |
| – Нийгмийн хамгаалал | 0.00% 0 |
| – Эрх тэгш боломжоор хангах | 0.00% 0 |
| – Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах | 0.00% 0 |
| – Гамшгийн эрсдэлийн удирдлага | 0.00% 0 |

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

| | |
|---|---|
| – Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих | 72.73% 8 |
| – Хүний хөгжлийг дэмжих | 54.55% 6 |
| – Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих | 54.55% 6 |
| – Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих | 36.36% 4 |
| – Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих | 18.18% 2 |
| – Бүгд чухал | 18.18% 2 |